



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Хала-Өркени” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **БӨА-2022/03/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:
www.audit.mn

Өлгий хот
2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: Х.Манаргүл

Утас: 95429524 Цахим хаяг: manargulx@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	Error! Bookmark not defined.
3.1 Байгууллагын үйл ажилагаа	6
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	6
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	7
4. Аудитын тайлан	6
4.1 Ерөнхий зүйл	8
4.2 Дотоод хяналт	8
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
4.4 Материаллаг байдал	9
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	9
5.1 Шилэн дансны мэдээлэл	9
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	9
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	10
8. Аудитын илрүүлэлт	10
8.1 Залруулсан алдаа	10
8.2 Төлбөрийн акт	10
8.3 Албан шаардлага	10
8.4 Зөвлөмж	10
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	10

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

**"ХАЛА-ӨРКЕНИ" ОНӨААТҮГ-ИЙН ДАРГА
У.САЛДАТБЕК ТАНАА**

2022.03.15 № 34
танай _____ -ны № _____ -т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Хала-Өркени" ОНӨААТҮГ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

"Хала-Өркени" ОНӨААТҮГ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

"Хала-Өркени" ОНӨААТҮГ-ийн 2021 оны санхүүгийн тайланг АОУС 706.7-д тодорхойлсон болон санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн мэдээллийг үнэн зөв толилуулж, тодруулсан байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудал

АОУС 706:10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар "Хала-Өркени" ОНӨААТҮГ-ийн аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  МХХАНГАН

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
А	Б	1	2
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	309,778.69	60,791.63
1.1.4	Бусад авлага	17,928,350.00	14,148,360.00
	Эргэлтийн хөрөнгийн дүн	18,238,128.69	14,209,151.63
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,323,206,430.62	1,173,091,852.51
1.2.2	Биет бус хөрөнгө	26,881,000.00	26,881,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,350,087,430.62	1,199,972,852.51
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,368,325,559.31	1,214,182,004.14
2.1.1.2	Цалингийн өглөг	1,826,108.73	7,995,470.27
2.1.1.3	Татварын өр	198,268.89	752,861.00
2.1.1.4	НДШ-ийн өглөг	1,122,197.36	2,997,091.26
2.1.1.6	Хүүний өглөг	2,400,000.00	2,400,000.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	5,546,574.98	14,145,422.53
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	20,000,000.00	20,000,000.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	20,000,000.00	20,000,000.00
2.1.2.10	Өр төлбөрийн нийт дүн	25,546,574.98	34,145,422.53
2.3	2. Эзэмшигчийн өмч		
2.3.1	Өмч: -төрийн	2,338,200,305.69	2,338,200,305.69
2.3.9	Хуримтлагдсан ашиг:	(995,421,321.36)	(1,158,163,724.08)
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,342,778,984.33	1,180,036,581.61
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,368,325,559.31	1,214,182,004.14

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
Борлуулалтын орлого (цэвэр)	7,355,756.72	6,650,000.00
Нийт ашиг /алдагдал/	7,355,756.72	6,650,000.00
Хүүний орлого	1,349.41	
Бусад орлого		9,900,000.00
Борлуулалт, маркетингийн зардал	160,014,078.11	160,414,578.11

Ерөнхий ба удирдлагын зардал	14,494,218.98	15,097,834.61
Бусад зардал	2,276,050.00	3,779,990.00
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(169,427,240.96)	(162,742,402.72)
Орлогын татварын зардал		
Татварын дараах ашиг (алдагдал)	(169,427,240.96)	(162,742,402.72)
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	(169,427,240.96)	(162,742,402.72)
Орлогын нийт дүн	(169,427,240.96)	(162,742,402.72)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12 сарын 31 үлд	2,338,200,305.69	-995,421,321.36	1,342,778,984.33
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(162,742,402.72)	(162,742,402.72)
2021 оны 12 сарын 31 үлд	2,338,200,305.69	(1,158,163,724.08)	1,180,036,581.61

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйлажиллагаанымөнгөнгүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	14,675,656.72	6,650,000.00
1.2	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	7,355,756.72	1,150,000.00
	Бусад мөнгөн орлого	7,319,900.00	5,500,000.00
	Мөнгөнзарлагын дүн (-)	14,385,532.02	6,898,987.06
1.3	Ажиллагчдад төлсөн	9,873,093.47	4,101,967.50
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,167,068.29	611,700.00
	Бараа материал худалданавахад төлсөн	460,000.00	1,200,500.00
	Ашиглалтын зардалд төлсөн	350,700.00	984,000.00
	Татварын байгууллагад төлсөн	596,100.26	
	Даатгалын төлбөрт төлсөн	938,570.00	819.56
	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	290,124.70	(248,987.06)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,349.41	-
2.3	Хүлээн авсан хүүний орлого	1,349.41	
	Хөрөнгө оруулалтынүйл ажиллагааны цэвэр мөнгөнгүйлгээний дүн	1,349.41	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	291,474.11	(248,987.06)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18,304.58	309,778.69
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	309,778.69	60,791.63

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Орлого	мян/төг	38107.9	0	14,677.0	(14,677.0)	
2	Зарлага	мян/төг	43309.3	0	14,385.5	(14,385.5)	

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Хала-өркени” ОНӨААТҮГ-ын зорилго нь Үйлчлүүлэгч, харилцагч, хэрэглэгчдэд хүртээмжтэй, чанартай ажил үйлчилгээ үзүүлэхэд оршино.

Тус газрын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг

- Нийтийн халуун ус, ундны усны үйлчилгээ үзүүлэх
- Усан бассейн, усан спорт, мөсөн гулгуурын үйлчилгээ
- Хүүхэд залуучуудын парк ажиллуулах, түүний тохижилт үйлчилгээ, засвар үйлчилгээг хийх
- Хавтангийн үйлдвэрийн туслах ажил
- Нийтийн эзэмшлийн газар, ногоон байгууламжийг цэцэгжүүлэх, арчлах
- Түрээсийн үйл ажиллагаа эрхлэх гэж тодорхойлжээ.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Хала-өркени” ОНӨААТҮГ нь Өлгий сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2013 оны 2 дугаар тогтоолоор байгуулагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Өлгий сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 25 тоот тогтоолоор томилж байгаа нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 “ж”, Орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 дэх заалтуудтай нийцсэн байна.

“Хала-өркени” ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд ямар нэгэн цалин, урамшуулал олгох шийдвэр гараагүй байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд жилд хоёр удаа хөрөнгийн толлого хийж, аймгийн орон нутгийн өмчийн газарт мэдээлсэн байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн

нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Энэ нь тайлант онд улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг гол орлого нь зууны улиралд Хүүхэд залуучуудын паркийн үйл ажиллагаанаас орлого нь бүрддэг учраас цар тахал Ковид-19 өвчин гарсантай холбоотой Улсын Онцгой комисс болон Аймгийн Онцгой комиссын шийдвэрээр 2020-2021 онуудад үйл ажиллагаа явуулаагүйтэй холбоотой байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд ямар нэгэн өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Хала-өркени” ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Сангийн яамнаас баталсан заавар аргачлалын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	309.8	60.8	(249.0)
Авлага	17,928.4	14,148.4	(3,780.0)
Үндсэн хөрөнгө	1,350,087.4	1,199,972.9	(150,114.6)
Нийт хөрөнгө	1,368,325.6	1,214,182.0	(154,143.6)
Өр төлбөр	25,546.6	34,145.4	8,598.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,342,779.0	1,180,036.6	(162,742.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,368,325.6	1,214,182.0	(154,143.6)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 0.06 сая төгрөг болж өмнөх оноос 0.2 сая төгрөгөөр буурсан ба арилжааны банк дахь харилцах дансны үлдэгдэл байна.

Авлага дансны үлдэгдэл 14,1 сая төгрөг болж 3.8 сая төгрөгөөр буурсан байна. Авлагын үлдэгдэлд 2014 оноос хойш он дамжсан хугацаа хэтэрсэн 14,1 сая төгрөгийн найдваргүй авлага байна.

Тайлант онд 17,9 сая төгрөгийн найдваргүй авлагын нөөц байгуулж, аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн “төлбөр гаргуулах эд хөрөнгө орлого байхгүй тухай” 01 дугаар актын дагуу нэг иргэнтэй холбоотой 3,7 сая төгрөгийн найдваргүй авлагыг данснаас хассан байна.

Үндсэн хөрөнгө дансы үлдэгдэл 150.1 сая төгрөгөөр буурсан нь Өлгий сумын ОНХС-гаас “Өлгий сумын 12 дугаар багийн халуун усны засварын ажил”-д 9.9 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлого авч, үндсэн хөрөнгөд 160.1 сая төгрөгийн элэгдэл байгуулсан нь нөлөөлжээ

Богино хугацаат өглөг оны эцэст 14.1 сая төгрөг болж өмнөх оноос 8.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд ковид-19 цар тахлын өвчин гарсантай холбоотой үйл ажиллагаа явуулаагүйгээс орлого дутуу төвлөрч ажиллагсадтай холбоотой тооцоогоор гарсан өглөг байна.

Урт хугацаат өр төлбөр дансанд Өлгий сумын Сум хөгжүүлэх сангаас 2014 онд авсан 20.0 сая төгрөгийн өр байна. Урт хугацаат өр төлбөрийн эргэн төлөлт хугацаандаа хийгдэхгүй байгаа нь ямар нэгэн орлогогүй эргэн төлөх боломжгүй байгаатай холбоотой байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Хала-өркени” ОНӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

2021 онд үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж ТУЗ-аар батлуулсан боловч Ковид -19 цар тахалтай холбоотой улсын онцгой комисс болон аймгийн онцгой комиссын шийдвэрийн дагуу ямар нэгэн үйл ажиллагаа явуулаагүй байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Хала-Өркени” ОНӨААТҮГ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгадагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Х.Манаргүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

“Хала-Өркени” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

“Хала-Өркени” ОНӨААТҮГ нь байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, батлуулж ажиллаагүй байна.

Тус газарт хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын алба байхгүй байна

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Хала-Өркени” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл/мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийн сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 174.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 3.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар 2.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

“Хала-Өркени” ОНӨААТҮГ нь 2021 онд нийт 54.8 сая төгрөгийн 14 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 6.6 сая төгрөгийн 12 мэдээллийг хугацаандаа байршуулж, оны эцэст үүссэн 14.1 сая төгрөгийн авлага, 34.1 сая төгрөгийн өглөг бүгд 48.2 сая төгрөгийн 2 мэдээллийг байршуулаагүй байна. Шилэн дансны мэдээллийн мэдээлсэн байдлын дундаж 85.7 хувьтай байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

[illegible]